



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

2025 оны 03-р сарын 17-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн 15 цагт цахимаар хуралдуулахаар товлосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
 - 2.3. Ногдол ашиг хуваарилах талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. Цахим хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д хүргүүлэх өдрийг 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2025 оны 03 дугаар сарын 24; 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2025 оны 03 дугаар сарын 24 болон 4 дүгээр сарын 08-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо

Дугаар 03

Улаанбаатар хот

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар;

7.2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд аудитын компаниас болон ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;

7.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

7.4. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийн танилцуулга;

7.5. Хурлын зар.

8. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр, цахимаар санал хураах зөвлөмжийг Хавсралт 2-оор, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар тус тус баталсугай.

9. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 4 дүгээр 30-ны өдрийн 15 цагаар тогтоосугай.

10. Саналын хуудсыг хүлээн авах, тоолох тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: С.Алтантуяа

Гишүүд: Т.Удвал, Э.Цасцэцэг

11. Цахим хурлыг зохион байгуулах комиссын даргаар З.Цэрэнчимэг томилсугай.

12. Цахимаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах ажлыг энэхүү тогтоолын 2-р хавсралтаар баталсан журмын дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс / З.Цэрэнчимэг/-д даалгасугай.

ДАРГА

Б.АЮУШ

